



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 4/40

Улаанбаатар хот

Г Үйлчлүүлэгчийг зөв таних журам Г
батлах тухай

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилт, Эрүүл мэндийн сайдын “Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт батлах тухай” А180 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн төвөөр үйлчлүүлж буй иргэдийн аюулгүй байдал, тохиолдож болзошгүй тохиолдол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Үйлчлүүлэгчийг зөв таних журам”-ыг нэгдүгээр, үйлчлүүлэгчийг зөв таньж буйг үнэлэх хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмч эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөн ажиллаж буйд хяналт тавьж ажиллахыг тасгийн эрхлэгч, эмч, ахлах сувилагч нарт даалгасугай.

3. Уг журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг нягтан бодогч /Ц.Тунгалаг/-д зөвшөөрсүгэй

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багт үүрэг болгосугай.

ДАРГА *М. Саруултуяа* Д. САРУУЛТУЯА



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 05 сарын 15 өдрийн
дугаар тушаалын 4 хавсралт

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Үйлчлүүлэгчийг зөв таньж, мэдээллийг бүрэн, үнэн зөв нягталж авснаар үйлчлүүлэгчид буруу эмчилгээ хийх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүсэх тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилготой.
- 1.2. Сэргээн засах төвийн үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлж буй бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд уг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

ХОЁР. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНЫЖ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗӨВ ХҮРГЭХ

- 2.1. Дараах ажилбар бүрийн өмнө үйлчлүүлэгчийг таних
 - 2.1.1. Үйлчлүүлэгчийг хооллохын өмнө
 - 2.1.2. Эм өгөхийн өмнө
 - 2.1.3. Тарилга хийхийн өмнө
 - 2.1.4. Сэргээн засах эмчилгээ, сувилгааний ажилбар, гардан үйлдлийн өмнө
 - 2.1.5. Амбулатори, үйлчлүүлэгчийн карт, өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх бүрийн өмнө
- 2.2. Дараах үйлчлүүлэгчийг зөв таньж, зөв тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
 - 2.2.1. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгч:
 - Хөхүүл хүүхэд
 - Хэл яриа сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгч, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч
 - Хэл мэдэхгүй, орчуулагч байхгүй гадны үйлчлүүлэгч, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч
 - Танин мэдэхүйн алдагдалтай (оюуны хомсдол, зан төрхийн өөрчлөлттэй) үйлчлүүлэгч, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч
 - 2.2.2. Тулгуур эрхтний бэрхшээлтэй үйлчлүүлэгч, эцэг эх, асран хамгаалагч
 - 2.2.3. Харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгч, эцэг эх, асран хамгаалагч
- 2.3 Үйлчлүүлэгчийг зөв танихдаа дараах хэрэгслийг ашиглана.
 - 2.3.1. Сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчийг угтах хэсэгт сонсголын бэрхшээлтэй эцэг эх, асран хамгаалагчтай харилцахад ашиглах нэмэлт хэрэгсэл /самбар, маркер эсвэл цаас, бал/-ыг ил байршуулсан байна.

- 2.3.2. Эрсдэлтэй үйлчлүүлэгчид дүрэмт хувцасыг үйлчлүүлэгч угтах (хүлээн авах) хэсэгт байршуулсан байна.

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИХ АРГА

- 3.1. Сэргээн засах төвийн амбулатори, эмчилгээний хэсэгт үйлчлүүлж буй үйлчлүүлэгчийг зөв таних 3-4 аргыг хэрэглэх ба үйлчлүүлэгч бүрт 2-оос доошгүй аргыг хэрэглэнэ. Үүнд:
- 3.1.1. Үйлчлүүлэгчийн овог, нэрийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас тодруулна.
- 3.1.2. Үйлчлүүлэгчийн төрсөн огноо эсвэл регистрийн дугаарыг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас тодруулна.
- 3.1.3. Амбулаторийн тусламж, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчийн авсан цагийг бататгаж асуух. Жишээ: Сайн байна уу? Таны хүүхдийг Бат овогтой Солонго гэдэг үү? Та 10 цаг 20 минутанд цаг авсан уу? Гэхээс илүүтэйгээр Сайн байна уу? Таны хүүхдийн овог нэр хэн бэ? Таны хүүхэд хэдэн цагийнх бэ? гэж тодруулан асууна.
- 3.1.4. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч дээрх асуултанд хариулж мэдэхгүй байвал Хүүхдийн эх хүүхдийн ягаан эрүүл мэндийн дэвтэр эсвэл төрсний гэрчилгээнээс тодруулж харж болно.
- 3.1.5. Эмчилгээний хэсгүүдэд байгаа үйлчлүүлэгчид таних тэмдэг бүхий дүрэмт хувцас өмсгөнө
- 3.2. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг зөв таних.
- 3.2.1. Үйлчлүүлэгчийг 2 аргаар танина.
- 3.2.2. Үйлчлүүлэгчийн ар гэрийн гишүүд, асран хамгаалагчаас шаардлагатай мэдээллийг авч баталгаажуулна.
- 3.2.3. Улбар шар өнгийн туузтай дүрэмт хувцас өмссөн эсэх
- 3.2.4. Харилцааны бэрхшээлтэй эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчтай харилцах болон Гадаад улсын иргэнтэй харилцах ажилтны жагсаалтыг Хүний нөөцийн менежер жил бүр тодорхойлж баталсан байна.
- 3.3. Эм өгөхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних
- 3.3.1. Эм өгөхийн өмнө 2 аргаар таних
- 3.3.2. Уух эмийн нэр эмчийн бичсэнтэй тохирч буйг нягтлах
- 3.3.3. Эмийн тун хэмжээ нь үйлчлүүлэгчийн нас, кг/жинд тохирч буйг нягтлах
- 3.3.4. Эмийн харшилтай эсэхийг нягтлах (ногоон өнгийн туузтай дүрэмт хувцас өмссөн эсэх)
- 3.4. Сэргээн засах эмчилгээ, сувилгааны ажилбар, гардан үйлдлийн хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних.

- 3.4.1. Сэргээн засах эмчилгээ, сувилгааны ажилбар, гардан үйлдлийн өмнө зөв таних 2 арга хэрэглэх
- 3.4.2. Ямар нэг өнгийн туузтай хувцас өмсөн эсэх
- 3.4.3. Сэргээн засах эмчилгээ, сувилгааны ажилбар, гардан үйлдэл хийх гэж буй талбай зөв эсэхийг нягтлах
- 3.4.4. Хөл, гарын баруун, зүүн талыг сайтар нягтлах
- 3.4.5. Сэргээн засах эмчилгээний үед харшилж байсан тухай асуух
- 3.5. Танин мэдэхүйн алдагдалтай (оюуны хомсдол, зан төрхийн өөрчлөлттэй) үйлчлүүлэгчийг зөв таних
- 3.5.1. Үйлчлүүлэгчийг 2 аргаар танина.
- 3.5.2. Үйлчлүүлэгчийн ар гэрийн гишүүд, асран хамгаалагчаас шаардлагатай мэдээллийг авч баталгаажуулна.
- 3.5.3. Амбулаториор үйлчлүүлэгчийн картан дээрх болон бичиг баримтны зурагтай заавал нягтлана.
- 3.5.4. Шар өнгийн туузтай дүрэмт хувцас өмссөн эсэх
- 3.6. Ерөнхий анхаарах зүйлс
- 3.6.1. Эмчилгээ хэсэгт ижил нэртэй үйлчлүүлэгчийг хамт оруулахгүй байх
- 3.6.2. Зөв танихад заавал 2 аргыг ашиглах
- 3.6.3. Өвчний түүх, амбулаториор үйлчлүүлэгчийн картанд үзлэг, шинжилгээг бичих, анхан шатны бичиг баримт хөтлөхдөө зөв таних 2 аргыг ашиглах
- 3.6.4. Эмчлүүлэх хэсэгт ижил нэртэй 2 ба түүнээс дээш үйлчлүүлэгч байгаа тохиолдолд өвчний түүхийн нүүрэн хэсэгт АНХААРАХ тэмдэглэгээг ЦЭНХЭР өнгийн стикер, пламастер гэх зэргээр тэмдэглэх.

ДӨРӨВ. ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСГӨХ

- 4.1. Эмчилгээний хэсэгт тохирох өнгийн туузтай дүрэмт хувцасыг ӨМСГӨХ:
- Хоол тэжээлийн цочмог дуталтай үйлчлүүлэгчид ЦЭНХЭР ЦООХОР имжээртэй
 - Цус багадалттай үйлчлүүлэгчид УЛААН ЦООХОР имжээртэй
 - Сульдаатай үйлчлүүлэгчид НОГООН ЦООХОР имжээртэй
 - Харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид УЛААН өнгө
 - Сонсгол хэл ярианы бэрхшээлтэй бол УЛБАР ШАР өнгө
 - Тулгуур эрхтний бэрхшээлтэй бол ХӨХ өнгө
 - Залгих чадвар сул, хахах эрсдэлтэй бол ЯГААН өнгө
 - Ижил нэртэй үйлчлүүлэгч эмчлүүлж буй бол ЦЭНХЭР өнгө
 - Зан төрхийн өөрчлөлттэй бол ШАР өнгө
 - Эм тариа, хоол хүнсний харшилтай үйлчлүүлэгчид бол НОГООН өнгө

ТАВ. ТОХИОЛДОЛ БҮРТГЭН МЭДЭЭЛЭХ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. Үйлчлүүлэгчийг зөв танихтай холбоотой гарсан тохиолдол /алдаа/-ыг ажилтан бүр ЭМТҮЧАБ-ын багт мэдээлнэ.
- 5.2. ЭМТҮЧАБ-ын баг нь тохиолдол бүртгэх журамд заасны дагуу 1а, 1б бол улирал тутам, 2, 3 тохиолдол болон алдааг тухай бүр нь бүртгэн авч шийдвэрлэнэ
- 5.3. Эрүүл мэндийг тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын баг нь “үйлчлүүлэгчийг зөв танихтай холбоотой” гарсан тохиолдол, алдааг бүртгэх, судалгаа, дүгнэлттэй ажиллах

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 05 сарын 02
өдрийн 1 дугаар тушаалын 3 хавсралт



1.3. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ЗӨВ ТАНИЖ БУЙГ ХЯНАСАН БҮРТГЭЛ

№	Овог нэр	Он,сар,өдөр	Он,сар,өдөр	Он,сар,өдөр	Он,сар,өдөр	Он,сар,өдөр
		ABCDE	ABCDE	ABCDE	ABCDE	ABCDE
1.						
2.						
3.						
4.						
5.						

- A. Үйлчлүүлэгчийн хооллохын өмнө зөв таньж байгаа эсэх
- B. Үйлчлүүлэгчид сэргээн засах эмчилгээ хийхийн өмнө зөв таньж байгаа эсэх
- C. Үйлчлүүлэгчид эм өгөхийн өмнө зөв таньж байгаа эсэх
- D. Ижил нэртэй хүүхэд байгаа эсэх
- E. Эрсдэлтэй үйлчлүүлэгчид тохирсон дүрэмт хувцас өмсгөсөн эсэх